



ТЕХНИКИЙН ДАВС ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар №107/2022

2022 оны 10-р сарын 03

Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх нөгөө талаас Ирмүүн бармат ХХК-ийг төлөөлж захирал Н.Зоригтбаатар /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.3, 34.1.5, Эрчим хүчний сайдын А/104 тоот гэрээ, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл

1.1. Нийлүүлэгч нь “Техникийн давс” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтад заасан барааг нэр төрөл, нэг бүрийн үнэ, техникийн үзүүлэлт, стандартын дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад нийлүүлнэ.

Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа

2.1. Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш 5 /тав/ хоногийн дотор нийлүүлнэ.

Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

- 3.1. Энэ гэрээний нийт үнэ 18,600,000 /Арван найман сая зургаан зуун мянга/-н төгрөг бөгөөд үнийн дүнд гааль Онцгой албан татвар, Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад хүргэх тээврийн зардал НӨАТ бүгд шингэсэн байна.
- 3.2. Захиалагчаас төлбөрийг нэхэмжлэлийн дагуу урьдчилан нийлүүлэгчийн Хаан банкны 5028195402 тоот дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

- 4.1. Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүлээгүй бол барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 4.2. Захиалагч нь төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг Нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.

- 4.3. Барааг Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад ирсэний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс шаардлага хангаж байгааг тогтоосон тохиолдолд барааг хүлээн авна. Барааг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана.
- 4.4. Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Амгалан дулааны станц ТӨХК-ийн Химийн инженер Д.Хишигшинэн хариуцан ажиллана. Утас- 88100929.
- 4.5. Нийлүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Ирмүүн бармат ХХК-ийн менежер Э.Одхүү хариуцан ажиллана. Утас-89281177.

Тав. Бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа, боодол

- 5.1. Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.
- 5.2. Бараа нь тээвэрлэлт, хадгалалтын үед норох, гоожихоос хамгаалсан сав, баглаа боодолтой байна.
- 5.3. Барааг захиалагчид хүлээлгэн өгөх үед энэхүү гэрээгээр тодорхойлсон шинж чанарт нийцэж байвал зохих бөгөөд цаашид технологийн горим, зориулалтын дагуу ашиглах хугацаанд чанараа алдахгүй байх ёстой.
- 5.4. Нийлүүлсэн бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй бараа илэрвэл дутагдлыг арилган, сольж өгөхийг Захиалагч шаардах ба нийлүүлэгч шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.5. Нийлүүлэгч нь нийлүүлсэн барааг ашиглаж эхэлсэн өдрөөс хойш 6 сарын баталгаа гаргана. Нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан алдаа, доголдлыг өөрийн зардлаар залруулах үүрэгтэй.
- 5.6. Барааг дараах бичиг баримт дагалдана.
 - Барааны шинжилгээний бичиг
 - Барааны гарал үүслийн гэрчилгээ

Зургаа. Бараа хүлээн авах

- 6.1. Нийлүүлэгч нь ачигдсан барааг Улаанбаатар хотын Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад буулгаж өгөх ба бараа хүлээн авах комисс хүлээн авна.
- 6.2. Нийлүүлэгч нь барааг Захиалагчид хүлээлгэн өгч дуусгах хүртэлх бүх зардлыг хариуцна.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1. Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчилэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 7.2. Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд 5 хоногийн дотор талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.


Найм. Гэрээг цуцлах үндэслэл

- 8.1. Нийлүүлэгч нь бараа материал нийлүүлэх энэхүү гэрээнд зааснаас 30 хоног хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ аваагүй тохиолдолд захиалагч гэрээг цуцлах ба баталгааг буцаан олгохгүй.
- 8.2. Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа буюу ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.


Ес. Бусад нөхцөл


- 9.1.Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 5 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2.Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3.Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж, Захиалагч 3 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4.Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.
- 9.5.Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.
- 9.6.Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7.Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
СЭЭХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ
Ө.УДВАЛ
Гарын үсэг: 

ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Г.ЭРДЭНЭБИЛЭГ
Гарын үсэг: 

НЭГДСЭН ЦЕХИЙН ДАРГА
Ж.АРИУНЖАРГАЛ
Гарын үсэг: 

ХИМИЙН ИНЖЕНЕР
Д.ХИШИГШИНЭН
Гарын үсэг: 

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН
Г.САРУУЛ
Гарын үсэг:

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН :
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН
Ш.ГАНТУЛГА
Гарын үсэг: 

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1 Утасны дугаар: 77111251
РД: 6021646

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ИРМҮҮН БАРМАТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Н.ЗОРИГТБААТАР
Гарын үсэг:



Хаяг: БЗД 13-р хороо 14-р хороолол 99-р байр
барилга мегастор 109 тоот
Утас: 89281177
РД: 2823969

Техникийн давс нийлүүлэх үнийн хуваарь

№	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	НӨАТ-тай үнэ
1	Техникийн давс	тн	20	930	18,600,000
	Нийт үнэ				18,600,000

Баталгаат хугацаа 6 сар байна. Нийлүүлэх хугацаа 5 хоног.

Амгалан дулааны станц ТӨХК-ийн

Нэгдсэн цехийн дарга

Ж.Ариунжаргал



Ирмүүн бармат ХХК-ийн

Захирал

Н.Зоригтбаатар

